



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 07 сарын 16 өдөр

Дугаар 146

Улаанбаатар хот

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Эрүүл мэндийн яамны 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. “Эмнэлгийн мэргэжилтний хариуцлагын даатгалын тухай” хуулийн үзэл баримтлал, төслийг боловсруулж, Засгийн газарт өргөн барих ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. “Эмнэлгийн мэргэжилтний хариуцлагын даатгалын тухай” хуулийн үзэл баримтлал, төслийг Засгийн газарт өргөн барьснаар ажлын хэсгийн үйл ажиллагааг дуусгавар болсонд тооцсугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2013 оны 35 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

080502

Эрүүл мэнд, спортын сайдын
2015. оны 04. сарын 16. өдрийн
146 тоот тушаалын хавсралт



“Эмнэлгийн мэргэжилтний хариуцлагын даатгалын тухай”
хуулийн үзэл баримтлал, төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн

- Ажлын хэсгийн ахлагч Д.Атармаа, Эрүүл мэнд, спортын дэд сайд
- Ажлын хэсгийн дэд ахлагч Р.Оюунханд, Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга
- Нарийн бичгийн дарга Н.Оюунгэрэл, Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн
- Ажлын хэсгийн гишүүд
- Ш.Мөнгөнцэцэг, Төрийн захиргааны удирдлагын газрын хууль эрх зүйн мэргэжилтэн;
- С.Гантуяа, Эмнэлгийн тусламжийн хэлстийн мэргэжилтэн;
- Г.Баясгалан, Улсын хоёрдугаар төв эмнэлгийн дарга;
- Ш.Энхтөр, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн дарга;
- Л.Ширнэн, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн судалгаа төлөвлөлт, статистик мэдээллийн албаны мэргэжилтэн;
- Д.Бямбасүрэн, Сайдын зөвлөлийн гишүүн /зөвшилцснөөр/;
- Ч.Нарантуяа, Эмнэлгийн ажилчдын үйлдвэрчний эвлэлийн нэгдсэн холбооны хуулийн зөвлөх/зөвшилцснөөр/;
- Д.Ганбат, Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн/зөвшилцснөөр/;
- Ж.Мягдагноров, Санхүүгийн зохицуулах хорооны даатгалын газрын Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах хянан шалгагч /зөвшилцснөөр/;
- Л.Мөнхдэмбэрэл, Сангийн яамны Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газрын санхүүгийн зээл, даатгалын хэлтсийн мэргэжилтэн /зөвшилцснөөр/.